



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуй нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуй нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.


3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуй нэгжүүдийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.


5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 20.15 оны 0.9 сарын 29 өдрийн А.БЗ
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.04.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Кондитер Улаанбаатар ХХК	Шинэ Алтай	Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 28
2	Бодь-Монгол ХХК	Бест	Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Их тойруу-15

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 20.17 оны 04 сарын 04 өдрийн 422 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.04.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Х.Мөнхжаргал	Тэгш	Сонгинохайрхан дүүрэг, 11-р хороо, Хонхорын 1/13 тоот
2	Иргэн Б.Нарантуяа	Стар	Сонгинохайрхан дүүрэг, 6-р хороо, Ханын материалын эцэс 18060/52
3	Иргэн С.Батмөнх	Зээргэнэ	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу
4	Хонгор икспедишн ХХК	Хонгор	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Тавин мянгатын 15/5 тоот
5	Тэлмэн Импекс ХХК	Сондор	Чингэлтэй дүүрэг, 13-р хороо, Дөрвөн буудал

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2015 оны 04 сарын 29 өдрийн 133 тоот
тушаалын гуравдугаар хавсралт



ЖУУЛЧНЫ БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2015.04.28

Улаанбаатар хот

<i>Д/д</i>	<i>Иргэн, аж ахуйн нэгжийн нэр</i>	<i>Оноосон нэр</i>	<i>Байршил</i>
1	Монголий вояж ХХК	Мөнх Тэнгэр - 2	Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Тайны амын зүүн ам

-ooOoo-